

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/222/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: [saranchimegts@audit.gov.mn](mailto:saranchimegts@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: [auditulziit@gmail.mn](mailto:auditulziit@gmail.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/117  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГА Б.ТУНГАЛАГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй бөгөөд бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант онд 1,800.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж

919020235

авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,443,583.09</b>	<b>6,600,966.61</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,185,381.00</b>	<b>1,342,764.52</b>
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	1,185,381.00	1,342,764.52
33101	Цалингийн авлага	1,185,381.00	
33102	НДШ-ийн авлага		1,342,764.52
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>5,258,202.09</b>	<b>5,258,202.09</b>
35400	Хангамжийн материал	5,258,202.09	5,258,202.09
35410	Бичиг хэргийн материал	1,044,130.00	1,139,430.00
35420	Аж ахуйн материал	3,040,572.09	2,806,272.09
35430	Сэлбэг хэрэгсэл	308,500	288,000
35470	Бусад хангамжийн материал	865,000	1,024,500
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>41,003,283.12</b>	<b>35,400,613.54</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>41,003,283.12</b>	<b>35,400,613.54</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>39,628,283.12</b>	<b>34,175,613.54</b>
39205	Машин тоног төхөөрөмж	29,835,800.00	32,574,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,087,157.80)	(10,175,146.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,207,701.00	13,466,871.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(328,060.08)	(1,690,912.22)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,375,000.00</b>	<b>1,225,000.00</b>
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(125,000.00)	(275,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>47,446,866.21</b>	<b>42,001,580.15</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>47,446,866.21</b>	<b>42,001,580.15</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>47,446,866.21</b>	<b>42,001,580.15</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	47,446,866.21	42,001,580.15
51210	Өмнөх үеийн үр дүн		47,062,361.05
51220	Тайлант үеийн үр дүн	47,446,866.21	(5,060,780.90)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>47,446,866.21</b>	<b>42,001,580.15</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>284,633,501.00</b>	<b>324,920,190.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12,135,601.00</b>	<b>1,800,153.80</b>
<b>1200</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>12,135,601.00</b>	<b>1,800,153.80</b>
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	11,816,601.00	1,800,153.80
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	319,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>272,497,900.00</b>	<b>323,120,037.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>200,455,700.0</b>	<b>227,613,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	200,455,700.0	227,613,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>59,981,000.00</b>	<b>95,506,737.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	59,981,000.00	95,506,737.00
1330	Төсвийн захирагчаас	12,061,200.00	
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,061,200.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>237,186,634.79</b>	<b>329,980,971.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>237,186,634.79</b>	<b>329,980,971.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>139,181,137.73</b>	<b>307,576,661.88</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>70,547,624.42</b>	<b>172,243,091.80</b>
210101	Үндсэн цалин	54,914,653.30	105,325,202.71
210102	Нэмэгдэл	5,824,703.22	38,604,040.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,350,000.00	8,700,000.00
210104	Урамшуулал	3,458,267.90	19,613,848.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>9,370,819.52</b>	<b>22,170,014.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	6,439,605.52	15,213,022.73
210202	Тэтгэмжийн даатгал	734,130.02	1,789,767.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	587,303.98	1,379,014.20
210204	Ажилгүйдлийн даатгал	141,519.87	340,672.78
210205	Эрүүл мэндийн даатгал	1,468,260.13	3,447,537.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,837,120.00</b>	<b>3,869,395.55</b>
210301	Гэрэл, цахилгаан	790,167.00	719,395.55
210302	Түлш, халаалт	902,600.00	3,150,000.00
210303	Цэвэр, бохир ус	144,353.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,217,536.00</b>	<b>8,152,342.00</b>
210401	Бичиг хэрэг	2,190,050.00	1,801,690.00
210402	Тээвэр, шатахуун	4,917,418.00	4,311,212.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	823,680.00	938,120.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,286,388.00	1,101,320.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>105,000.00</b>	
210502	Хоол, хүнс	105,000.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>640,000.00</b>
210702	Дотоод албан томилолт		640,000.00

Төв аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,420,955.91</b>	<b>39,105,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,420,955.91	39,105,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>43,682,081.88</b>	<b>61,395,918.22</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,141,864.00	53,627,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,540,217.88	7,768,318.22
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>98,005,497.06</b>	<b>22,404,309.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,150,000.00</b>	<b>360,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,150,000.00	360,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	96,855,497.06	22,044,309.82
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		3,830,089.06
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	96,855,497.06	18,214,220.76
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>47,446,866.21</b>	<b>(5,060,780.90)</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>47,446,866.21</b>	<b>(5,060,780.90)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>47,446,866.21</b>	<b>(5,060,780.90)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>272,497,900.00</b>	<b>323,120,037.00</b>
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>272,497,900.00</b>	<b>323,120,037.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>272,497,900.00</b>	<b>323,120,037.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	200,455,700.00	227,613,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	200,455,700.00	227,613,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	59,981,000.00	95,506,737.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	59,981,000.00	95,506,737.00
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>	12,061,200.00	
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	12,061,200.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>241,854,000.00</b>	<b>323,555,418.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>241,854,000.00</b>	<b>323,555,418.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>143,848,502.94</b>	<b>301,151,108.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>71,733,005.42</b>	173,585,856.32
210101	Үндсэн цалин	56,268,838.07	106,667,967.23
210102	Нэмэгдэл	5,685,899.45	38,604,040.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,320,000.00	8,700,000.00
210104	Урамшуулал	3,458,267.90	19,613,848.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>9,370,819.52</b>	<b>22,170,014.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	6,439,605.52	15,213,022.73
210202	Тэтгэмжийн даатгал	734,130.02	1,789,767.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	587,303.98	1,379,014.20
210204	Ажилгүйдлийн даатгал	141,519.87	340,672.78
210205	Эрүүл мэндийн даатгал	1,468,260.13	3,447,537.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,837,120.00</b>	<b>3,869,395.55</b>
210301	Гэрэл, цахилгаан	790,167.00	719,395.55
210302	Түлш, халаалт	902,600.00	3,150,000.00
210303	Цэвэр, бохир ус	144,353.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,525,640.00</b>	<b>8,152,342.00</b>
210401	Бичиг хэрэг	3,294,780.00	1,801,690.00
210402	Тээвэр, шатахуун	4,487,292.00	4,311,212.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	823,680.00	938,120.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	919,888.00	1,101,320.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>372,500.00</b>	
210601	Багаж, техник, хэрэгсэл	372,500.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>640,000.00</b>

Төв аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт		640,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,880,172.00</b>	<b>39,105,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,880,172.00	39,105,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,129,246.00</b>	<b>53,627,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,129,246.00	53,627,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>98,005,497.06</b>	<b>22,404,309.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,150,000.00</b>	<b>360,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,150,000.00	360,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг</b>	96,855,497.06	22,044,309.82
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		3,830,089.06
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	96,855,497.06	18,214,220.76
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>30,643,900.00</b>	<b>(435,381.00)</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>		<b>1,185,381.00</b>
<b>14</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>		<b>1,185,381.00</b>
140	Төсөвт байгууллагын орлого		1,185,381.00
140020	Дансны орлого		1,185,381.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>30,643,900.00</b>	<b>750,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,643,900.00</b>	<b>750,000.00</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	30,643,900.00	750,000.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	30,643,900.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		750,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(30,643,900.00)</b>	<b>435,381.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>47,446,866.21</b>	<b>47,446,866.21</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			-	-
Тайлант үеийн үр дүн			<b>47,446,866.21</b>	<b>47,446,866.21</b>
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>47,446,866.21</b>	<b>47,446,866.21</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(384,505.16)	(384,505.16)
<b>Дахин илэрхийлсэн</b>			47,062,361.05	47,062,361.05
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			<b>(5,060,780.90)</b>	<b>(5,060,780.90)</b>
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>42,001,580.15</b>	<b>42,001,580.15</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>227,613,300.00</b>	<b>227,613,300.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>227,234,900.00</b>	<b>227,234,900.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
Татварын бус орлого	227,234,900.00	227,234,900.00	0.00	100%
Тусламжийн орлого	227,234,900.00	227,234,900.00	0.00	100%
Төсвөөс санхүүжих	378,400.00	378,400.00	0.00	100%
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>227,234,900.00</b>	<b>227,234,900.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>227,613,300.00</b>	<b>210,224,460.24</b>	<b>17,010,439.76</b>	<b>92.51%</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>227,613,300.00</b>	<b>210,224,460.24</b>	<b>17,010,439.76</b>	<b>92.51%</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<b>178,910,400.00</b>	<b>164,371,058.13</b>	14,539,341.87	91.87%
Үндсэн цалин	106,216,600.00	106,667,967.23	(451,367.23)	100.43%
Нэмэгдэл	55,821,600.00	29,389,242.10	26,432,357.90	52.65%
Унаа хоолны хөнгөлөлт	11,220,000.00	8,700,000.00	2,520,000.00	77.54%
Урамшуулал	5,652,200.00	19,613,848.80	(13,961,648.80)	347.01%
<b>Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл</b>	<b>22,363,800.00</b>	<b>21,018,164.56</b>	<b>1,345,635.44</b>	<b>93.98%</b>
Тэтгэврийн даатгал	15,207,400.00	14,429,764.88	777,635.12	94.89%
Тэтгэмжийн даатгал	1,789,100.00	1,697,619.41	91,480.59	94.89%
ҮОМШӨ-ний даатгал	1,431,300.00	1,305,295.83	126,004.17	91.20%
Ажилгүйдлийн даатгал	357,800.00	322,243.19	35,556.81	90.06%
Эрүүл мэндийн даатгал	3,578,200.00	3,263,241.25	314,958.75	91.20%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,973,100.00</b>	<b>4,973,100.00</b>	<b>1,103,704.45</b>	<b>77.81%</b>
Гэрэл, цахилгаан	2,658,100.00	719,395.55	1,938,704.45	27.06%
Түлш, халаалт	1,850,200.00	3,150,000.00	(1,299,800.00)	170.25%
Цэвэр, бохир ус	464,800.00		464,800.00	
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,656,600.00</b>	<b>4,652,342.00</b>	<b>4,258.00</b>	<b>99.91%</b>
Бичиг хэрэг	1,563,000.00	1,801,690.00	(238,690.00)	115.27%
Тээвэр, шатахуун	590,100.00	811,212.00	(221,112.00)	137.47%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,314,700.00	938,120.00	376,580.00	71.36%
Хог хаягдал зайлуулах, мэрэгчдийг устгал	70,800.00		70,800.00	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,118,000.00	1,101,320.00	16,680.00	98.51%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>11,702,100.00</b>	<b>11,685,900.00</b>	<b>16,200.00</b>	<b>99.86%</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,702,100.00	11,685,900.00	16,200.00	99.86%

Төв аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,628,900.00</b>	<b>4,627,600.00</b>	<b>1,300.00</b>	<b>99.97%</b>
<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>		<b>17,010,439.76</b>	<b>(17,010,439.76)</b>	
<b>Урсгал шилжүүлэг</b>	378,400.00	360,000.00	18,400.00	95.14%
<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>		<b>18,400.00</b>	<b>(18,400.00)</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
АЖИЛЛАГСДЫН ТОО	11	9	2	
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	8	6	2	
Үйлчлэх ажилтан	2	2		

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)</b>	<b>95,506,737.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>95,506,737.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>91,676,647.94</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>9,214,798.19</b>
210102	Нэмэгдэл	9,214,798.19
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,151,849.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	783,257.85
210202	Тэтгэмжийн даатгал	92,147.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	73,718.37
210204	Ажилгүйдлийн даатгал	18,429.59
210205	Эрүүл мэндийн даатгал	184,295.96
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,500,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>640,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	640,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>28,170,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,170,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>49,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,830,089.06</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,830,089.06</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,830,089.06
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)</b>	<b>95,506,737.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>95,506,737.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>95,506,737.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	95,506,737.00
<b>11000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>12000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Соёл урлагийн газар нь орон нутгийн түвшинд үндэсний бахархал, эх хэл, уламжлал өв соёлоо дээдэлсэн, эх оронч, оюунлаг бүтээлч Монгол хүнийг хөгжүүлэх, улс орны хөгжлийн шинэ нөхцөл байдал, нийгмийн оюун сэтгэлгээний эрэлт хэрэгцээтэй уялдан нийтийн соёлын ойлголт, дэвшилтийг өргөн нэвтрүүлэх, соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалах, хүн амд төрөөс үзүүлэх соёлын олон талт үйлчилгээг өргөтгөн сайжруулахад соёлын салбарын хөгжлийг хангах чиг үүрэг бүхий Соёлын яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Соёл урлагийн газар нь 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 32 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 97,8%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Соёл урлагийн газар нь соёл урлагийн хэлтэс-төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хариуцсан чиг үүрэгтэй, захиргаа удирдлагын хэлтэс-нийтлэг чиг үүрэгтэй бүтэц, зохион байгуулалттай ба тайлант онд соёл урлагийн газрын дарга 1, захиргаа удирдлагын хэлтсийн дарга 1, соёл, урлагийн хэлтсийн дарга 1 мэргэжилтэн 6, үйлчилгээний ажилтан 2, бүгд 11 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Соёл урлагийн газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Соёлын тухай хууль

Төв аймгийн Соёл урлагийн газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн "Дотоод хяналт шалгалтын зөвлөл байгуулах тухай" А/11 тушаал, 5 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Соёл урлагийн газрын дотоод хяналт шалгалтын зөвлөл нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар арга хэмжээ төлөвлөж ажиллаагүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Соёл урлагийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн Соёлын сайдын А/02 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Соёл урлагийн газар нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,445.3 мянган төгрөгөөр буюу 11,48 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,185.4	1,342.7	157.3
Бараа материал	5,258.2	5,258.2	0
Үндсэн хөрөнгө	41,003.3	35,400.6	5,602.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>47,446.9</b>	<b>42,001.6</b>	<b>(5,445.3)</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	47,446.9	42,001.6	(5,445.3)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>47,446.9</b>	<b>42,001.6</b>	<b>(5,445.3)</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө данс байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд машин тоног төхөөрөмж 2,739.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 259.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 750.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, 259.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,989.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж шилжүүлэн авснаар нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 42,001.6 мянган төгрөг болж 5,445.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 240,626.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Соёл урлагийн газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 13,013.1 мянган төгрөгөөр бууруулж 2023 оны урсгал зардлын төсвийг 227,613.3 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 227,613.3 мянган төгрөгөөс 4 удаа тодотгол хийж 227,613.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 227,234.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 17,010.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 210,224.5 мянган төгрөг буюу 92,5 хувьтай байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702-Соёл урлаг	227,613.3	210,584.5	17,028.5	92.5%
2	80101-Үндсэн үйл ажиллагаа	227,234.9	210,224.5	17,010.1	92.5%
4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж,	378.4	360.0	18.4	95.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Соёл урлагийн газраас нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 95,506.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Соёл урлагийн газраас тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 10,366.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 3,500.0 мянган төгрөг, томилолт зочны зардалд 640.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 49,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 28,170.0 мянган төгрөг нийт 91,676.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлагыг зүйл тус бүрээр 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

#### Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Соёл, урлаг хөгжүүлэх	11-12 сар		69%	12,340.0	8,510.0
2	Түүхэн ой	6-12 сар	72,800.0	100%	72,800.0	72,800.0
3	Үндсэн үйл ажиллагааны бусад	9-12 сар	10,366.7	99.9%	10,366.7	10,366.5

Төв аймгийн Соёл урлагийн газраас соёлын эрхийн хүрээнд 16-18 хүүхдүүдэд соёлын боловсролыг хүргэх хөтөлбөрийн зардлыг 69,0 хувьтай хүрч үйлчилсэн байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төв аймгийн Соёл урлагийн газраас тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 14,187.8 төгрөгийн барааг шууд худалдан авалтаар авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 19,602.1 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан бараа, ажил үйлчилгээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав нар хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 237,186.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,557.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,668.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,103.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 4,258.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 16,200.0 мянган төгрөг нийт 21,561.7 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 159 мэдээллээс 153 мэдээллийн хугацаандаа, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа болоогүй хүлээгдэж байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Соёл урлагийн газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 албан шаардлага өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/166 албан тоотоор хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,242.0	1	2,242.0	100%
Албан шаардлага	2	877.5	2	877.5	100%
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>3,119.5</b>	<b>3</b>	<b>3,119.5</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Соёл урлагийн газарт дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### Залруулсан алдаа

Аудитаар нийт 49,253.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

1. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл дүн 47,446.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал, "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Хөрөнгийн элэгдлийн жилийг зөрүүтэй тогтоосны улмаас 384.5 мянган төгрөгийн элэгдлийг алдаатай тооцсон байна. Энэ нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг, алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Санхүүгийн тайлангаарх бараа материалын эцсийн үлдэгдэл, нярвын тайлангийн үлдэгдлээс 1,422.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 2,265.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 922.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,342.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

Шатахууны 1-12 сарын орлого, зарлагыг бүртгэж тайлан бэлтгээгүй, жолоочийн тооцооны хуудас хөтөлж спидометрийн заалтыг тэмдэглээгүй, хэн, хаашаа, явсан нь тодорхой бус 922.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Зам тээврийн сайдын 2019 оны 390-р тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн, 5.1.4-т үнэн зөв байх зарчмыг хэрэгжүүлэн ажиллах", 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэж заасантай нийцэхгүй, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн 922.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дансны авлагатай холбоотой асуудал.

Илрүүлэлт: 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар Нийгмийн даатгалын байгууллагаас НДШ 1,342.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал, "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийн дагуу тайлант хугацаанд авлага үүсгэхгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл дүн зөрүүтэй	1	47,446.8			1	47,446.8	1	47,446.8				
Хөрөнгийн элэгдлийн жилийг зөрүүтэй илэрхийлсэн	1	384.5			1	384.5	1	384.5				
Санхүүгийн тайлангаарх бараа материалын эцсийн үлдэгдэл, нярвын тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй байна.	1	1,422.4			1	1,422.4	1	1,422.4				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>49,253.7</b>			<b>3</b>	<b>49,253.7</b>	<b>3</b>	<b>49,253.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахуун зарцуулалтад хяналт тавьж, жолоочийн тооцооны хуудас хөтлөх	1	922.4	1	922.4								
Хууль тогтоомжийн дагуу тайлант хугацаанд авлага үүсгэхгүй байх	1	1,342.8					1	1,342.8				



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 69-17225502-ТӨА-2024/222/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар жолоосчийн тооцооны хуудас хөтөлж, тооцоо бодоогүй 922,399.00 төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн, 5.1.4-т үнэн зөв байх зарчмыг хэрэгжүүлэн ажиллах, 20 дугаар зүйлийн 20.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", Зам тээврийн сайдын 2019 оны 390-р тушаалыг, Санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Соёл урлагийн газрын дарга Б.Тунгалаг, нягтлан бодогч Д.Бямбацэрэн нараар 922,399.00 /Есөн зуун хорин хоёр мянга гурван зуун ерэн ес/ төгрөгийг төлүүлэн Төв аймгийн Төрийн сан дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Соёл урлагийн газрын дарга Б.Тунгалаг, нягтлан бодогч Д.Бямбацэрэн нар нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ

<sup>1</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

0149050355